БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# Хишиг-Өндөр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/89/НА-СТА-ТШ3


Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном
Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn



Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг

2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ................................................ **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ................................................ 5
3. Аудитын тайлан................................................ 10
3.1 Ерөнхий зүйл................................................ 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ................................................ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ................................................ 11
3.4 Материаллаг байдал ................................................ 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга................................................ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв................................................ 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг................................................ 13
3.8 Аудитын гол асуудал ................................................ 13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........... 13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ................................................ 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал................................................ 14
4. Аудитын илрүүлэлт ................................................ 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ................................................ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 93

танай ______________ ны № ______________ т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.БААСАНСҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хишиг-Өндөр сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хишиг-Өндөр сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020154

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 59,269,826.40 | 55,285,960.88 |
| 33 | АВЛАГА | 8,850,000.00 | - |
| 335 | Бусад авлага | 8,850,000.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 8,850,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 50,419,826.40 | 55,285,960.88 |
| 351 | Түүхий эд материал | 5,266,500.00 | 5,336,100.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 5,108,500.00 | 5,117,900.00 |
| 35130 | Эм боох материал | 158,000.00 | 218,200.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 7,797,839.40 | 13,105,073.88 |
| 354 | Хангамжийн материал | 37,239,887.00 | 36,844,787.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 459,650.00 | 176,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 23,592,737.00 | 25,158,197.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 9,329,000.00 | 8,064,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 225,000.00 | 225,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,513,000.00 | 247,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,201,600.00 | 918,190.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 918,900.00 | 2,055,000.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 115,600.00 | - |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 463,588,274.16 | 444,491,204.80 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 463,588,274.16 | 444,491,204.80 |
| 392 | Биет хөрөнгө | 450,652,274.16 | 431,892,704.80 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 763,601,311.32 | 763,601,311.32 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (379,384,453.71) | (396,096,565.11) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 35,551,900.00 | 46,202,700.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (12,125,229.70) | (20,139,824.43) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 68,756,919.00 | 69,206,919.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (29,170,673.75) | (34,304,336.98) |
| 39217 | Ном | 3,422,501.00 | 3,422,501.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 12,936,000.00 | 12,598,500.00 |
| 39301 | Програм хангамж | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (337,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,586,000.00 | 11,586,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 522,858,100.56 | 499,777,165.68 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 522,858,100.56 | 499,777,165.68 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 522,858,100.56 | 499,777,165.68 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 118,320,473.00 | 118,320,473.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 118,320,473.00 | 118,320,473.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 80,623,383.70 | 57,542,448.82 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 80,623,383.70 | 80,623,383.70 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (23,080,934.88) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 323,914,243.86 | 323,914,243.86 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 522,858,100.56 | 499,777,165.68 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 384,151,800.00 | 382,413,045.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 364,652,100.00 | 330,708,300.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,231,000.00 | 2,880,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,231,000.00 | 2,880,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,231,000.00 | 2,880,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 849,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 849,000.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 356,421,100.00 | 326,979,300.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 356,421,100.00 | 326,979,300.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 19,499,700.00 | 51,704,745.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 200,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 200,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 19,499,700.00 | 51,504,745.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,499,700.00 | 51,504,745.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 395,928,262.44 | 405,493,979.88 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 395,928,262.44 | 405,493,979.88 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 342,531,886.44 | 380,589,691.88 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 234,188,465.00 | 241,172,479.00 |
| 210101 | Үндсэн цалин | 167,116,549.00 | 142,324,272.00 |
| 210102 | Нэмэгдэл | 42,661,976.00 | 75,280,357.00 |
| 210104 | Урамшуулал | 24,409,940.00 | 23,567,850.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,860,331.00 | 32,247,553.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,277,908.00 | 22,679,595.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,401,982.00 | 2,347,422.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,914,569.00 | 1,937,021.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 478,715.00 | 472,086.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,787,157.00 | 4,811,429.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,225,458.00 | 50,878,535.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,497,515.00 | 3,344,812.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,667,943.00 | 47,221,664.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 60,000.00 | 312,059.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,362,953.06 | 4,397,473.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 855,350.00 | 793,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,237,133.06 | 1,373,670.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 483,700.00 | 480,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 67,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 695,720.00 | 789,050.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 976,500.00 | 718,100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 25,000.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 89,550.00 | 176,403.00 |
| 2105 | Нормативт зардал | 18,012,390.00 | 11,689,937.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 267,600.00 | 47,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,987,940.00 | 10,736,247.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 756,850.00 | 905,790.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,400.00 | 2,189,850.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 390,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,400.00 | 1,799,850.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 304,000.00 | 126,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 304,000.00 | 126,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 677,500.00 | 1,359,590.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 461,500.00 | 1,359,590.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,898,389.38 | 36,528,274.88 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,130,000.00 | 497,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,868,090.00 | 5,833,005.52 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 27,900,299.38 | 30,197,869.36 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 53,396,376.00 | 24,904,288.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 598,300.00 | 537,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 598,300.00 | 537,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 52,798,076.00 | 24,366,388.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 52,798,076.00 | 24,366,388.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (11,776,462.44) | (23,080,934.88) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 567,152.03 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 392,152.03 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 175,000.00 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (567,152.03) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (12,343,614.47) | (23,080,934.88) |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 118,320,473.00 | 323,914,243.86 | 92,966,998.17 | 535,201,715.03 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **118,320,473.00** | **323,914,243.86** | **92,966,998.17** | 535,201,715.03 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (12,343,614.47) | (12,343,614.47) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **118,320,473.00** | **323,914,243.86** | **80,623,383.70** | **522,858,100.56** |
| D01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | **118,320,473.00** | **323,914,243.86** | **80,623,383.70** | **522,858,100.56** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | **118,320,473.00** | **323,914,243.86** | **80,623,383.70** | **522,858,100.56** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | (23,080,934.88) | | (23,080,934.88) |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | **118,320,473.00** | **323,914,243.86** | **57,542,448.82** | 499,777,165.68 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 385,613,280.00 | 381,649,255.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 366,113,580.00 | 329,944,510.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 9,692,480.00 | 2,965,210.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 9,692,480.00 | 2,965,210.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,692,480.00 | 2,965,210.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 356,421,100.00 | 326,979,300.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 356,421,100.00 | 326,979,300.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 19,499,700.00 | 51,704,745.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 200,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 200,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 19,499,700.00 | 51,504,745.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,499,700.00 | 51,504,745.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 374,235,780.00 | 373,957,455.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 374,235,780.00 | 373,957,455.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 320,839,404.00 | 348,991,067.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 234,188,465.00 | 241,172,479.00 |
| 210101 | Үндсэн цалин | 167,116,549.00 | 142,324,272.00 |
| 210102 | Нэмэгдэл | 42,661,976.00 | 75,280,357.00 |
| 210104 | Урамшуулал | 24,409,940.00 | 23,567,850.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,860,331.00 | 32,247,553.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,277,908.00 | 22,679,595.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,401,982.00 | 2,347,422.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,914,569.00 | 1,937,021.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 478,715.00 | 472,086.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,787,157.00 | 4,811,429.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18,026,408.00 | 50,505,195.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,497,515.00 | 3,344,812.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,998,893.00 | 46,797,724.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 530,000.00 | 362,659.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,191,450.00 | 5,068,570.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 499,700.00 | 496,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,259,430.00 | 1,258,920.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 483,700.00 | 480,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 67,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,697,820.00 | 1,694,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,250,800.00 | 1,071,300.00 |
| 2105 | Нормативт зардал | 16,792,100.00 | 14,231,140.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 63,000.00 | 63,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,123,150.00 | 13,553,950.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 605,950.00 | 614,090.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000,000.00 | 1,347,250.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 347,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 999,550.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 304,000.00 | 126,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 304,000.00 | 126,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 696,800.00 | 1,564,640.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 480,800.00 | 1,564,640.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,779,850.00 | 2,728,240.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,167,450.00 | 1,089,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,612,400.00 | 1,638,340.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 53,396,376.00 | 24,966,388.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 598,300.00 | 600,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 598,300.00 | 600,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 52,798,076.00 | 24,366,388.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 52,798,076.00 | 24,366,388.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 11,377,500.00 | 7,691,800.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 11,377,500.00 | 7,691,800.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 11,377,500.00 | 7,691,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 11,377,500.00 | 7,691,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 7,691,800.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 11,377,500.00 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (11,377,500.00) | (7,691,800.00) |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 378646200.00 | 357082867.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 378646200.00 | 349391067.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 378046200.00 | 348791067.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 247005100.00 | 241172479.00 |
| 210101 | Үндсэн цалин | 151415200.00 | 142324272.00 |
| 210102 | Нэмэгдэл | 68452400.00 | 75280357.00 |
| 210104 | Урамшуулал | 27137500.00 | 23567850.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33505700.00 | 32247553.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23625600.00 | 22679595.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2502000.00 | 2347422.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1944000.00 | 1937021.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 494000.00 | 472086.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4940100.00 | 4811429.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 50666900.00 | 50505195.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3400000.00 | 3344812.00 |
| 210302 | Түлш, халаалт | 46904200.00 | 46797724.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 362700.00 | 362659.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7924900.00 | 4868570.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 500000.00 | 496600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1260000.00 | 1258920.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 483,700.00 | 480,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 68,800.00 | 67,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,500,000.00 | 1,494,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,112,400.00 | 1,071,300.00 |
| 2105 | Нормативт зардал | 28,519,800.00 | 14,231,140.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 63,100.00 | 63,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,842,600.00 | 13,553,950.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 614,100.00 | 614,090.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,000,000.00 | 1,347,250.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 | 347,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 999,550.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 129,500.00 | 126,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 129,500.00 | 126,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,566,000.00 | 1,564,640.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,566,000.00 | 1,564,640.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,728,300.00 | 2,728,240.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,089,900.00 | 1,089,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,638,400.00 | 1,638,340.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 600,000.00 | 600,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 600,000.00 | 600,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 600,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 7,691,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 7,691,800.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 7,691,800.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 54,469,955.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | 51,504,745.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | - | 51,504,745.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | - | 2,965,210.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,965,210.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 200,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 200,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 200,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 200,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 200,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 200,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 200,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 200,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хишиг-Өндөр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хишиг-Өндөр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хишиг-Өндөр сумын хүүхдийн цэцэрлэг нь “СӨБ-д хамрагдах шаардлагатай сумын тойргийн хүүхдийн бүрэн хамруулах, багшийн хөгжлийг дэмжих. Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилгыг хүрээн 5 зорилтын хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

1. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх,
2. Цэцэрлэгийн барилгын их засварыг гүйцэтгэх өргөтгөх замаар хүртээмжийг нэмэгдүүлэх,
3. Багш ажилчдын мэдлэг, мэргэшил, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтын чанарыг сайжруулж шинэ багш төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ,
4. Хүүхдийг эрүүл шим тэжээллэг хоол хүнсээр хангаж,
5. хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж, чанар хүртээмжийг нэмэгдүүлэн гэсний дагуу хяналт шалгалт цаг тухайд нь хийж гүйцэтгэжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хишиг-Өндөр сумын хүүхдийн цэцэрлэгийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хишиг-Өндөр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 374.сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хишиг-Өндөр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19.1 сая төгрөгөөр буурсан нь тухай жилийн элэгдэлтэй холбоотой байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мян.төг /

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 8,850.0 | 0 | 8,850.0 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 50,419.8 | 55,285.9 | -4,866.1 |
| Үндсэн хөрөнгө | 463,588.3 | 444,491.2 | 19,097.0 |
| Нийт хөрөнгө | 522,858.1 | 499,777.2 | 23,080.9 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 522,858.1 | 499,777.2 | 23,080.9 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 522,858.1 | 499,777.2 | 23,080.9 |

**Авлага:** Тайлант онд авлагын эхний үлдэгдэл болох 8.9 сая төгрөгийн авлагыг барагдуулж тайлант онд 0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Бараа материал:** Бараа материалын оны эхний үлдэгдэл 50.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 55.3 сая төгрөг болж өмнөх оноос 4.9 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 32.7, үнэ төлбөргүй 0.3 нийт 33.1 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс үүссэн байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 463.6, эцсийн үлдэгдэл 444.5 сая төгрөг болж өмнөх оноос 19.1 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 7.7, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд шилжүүлсэн болон акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

**Өр төлбөр:** Тайлант онд өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг сая төгрөгөөр, нийт зарлагыг 489.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 111.0 сая төгрөгөөр бууруулан 378.5 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн 71801 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 378.5 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 51.5 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 3.0, тусгай зориулалтын шилжүүлгээс 327.0 сая төгрөг нийт 381.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж,

урсгал үйл ажиллагаанд 357.1 сая төгрөгийг зарцуулж 24.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Боловсрол соёл урлагийн газраас 0.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж. Үүнээс 0.2 сая төгрөгийг зарцуулж 0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 6.4 хувиар буюу 24,366.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан,
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсвөөс 161.7 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Таван сая төгрөгөөс дээш 21 удаагийн 213,820.8 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дэх заалтыг зөрчсөн байна. Энэ нь Шилэн дансны тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 37 нэр төрлийн 13,403.8 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй тайланд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4.5-д "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 523,900.4 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 1,350.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 6,050.6 мянган төгрөгийн 5 төлбөрийн актыг улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтоож, 6,105.3 мянган төгрөгийн зөрчилд таслан зогсоох 1 албан шаардлага өгч, 51,691.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь | Тоо | Дүн |
| Төлбөрийн акт | 5 | 5,990.6 | 3 | 2,835.1 | 47.3% | 2 | 3,155.5 |
| Албан шаардлага | 1 | 6,105.3 | 1 | 6,105.3 | 100% | - | - |
| Зөвлөмж | 2 | 51,691.9 | 2 | 51,691.9 | 100% | - | - |
| **Нийт дүн** | **8** | **63,787.8** | **6** | **60,632.3** | **82.4%** | **2** | **3,155.5** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 227,508.4 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 176.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 107.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг тогтоож, 213,820.0 мянган төгрөгийн зөрчилд таслан зогсоох 1 албан шаардлага өгч, 13,403.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

Акталж устгасан 176.4 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан зарцуулсан гэж бичилт хийснийг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Тайлант онд анхан шатны баримтын бүрдэл дутуу 107,550.0 төгрөгийн шатахууныг зарцуулсан байна. Энэ нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Таван сая төгрөгөөс дээш 21 удаагийн 213,820.9 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь шилэн дансны тухай хуулийн 6.4.4 дэх заалтыг зөрчсөн байна. Энэ нь Шилэн дансны тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4.5-д "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

**Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:**

***1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой***

1.1. *<u>Илрүүлэлт:</u>*

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 37 төрлийн 13.4 сая төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй, данс бүртгэлээс хасаагүй тайланд тусгасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Элэгдлийн нийт хэмжээ ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох болон данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

*/сая төгрөгөөр/*

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хишиг-Өндөр сумын цэцэрлэг | 4 | 227.5 | 1 | 0.2 | 1 | 0.1 | 1 | 213.8 | 1 | 13.4 |
| Нийт дүн | | 4 | 227.5 | 1 | 0.2 | 1 | 0.1 | 1 | 213.8 | 1 | 13.4 |